

МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН



ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВ БАЙДАЛ

Ц.Цэцэгмаа Доктор (Ph.D) Дэд проф
Н.Болдмаа Доктор (Ph.D) Дэд проф
С.Боловсон
Л.Банзрагч

General situation of Occupational safety and health in the MONGOLIAN MINING sector

Хураангуй

Энэхүү өгүүлэлд Монгол Улсын уул уурхайн салбарын ХАБЭА-н төлөв байдлыг холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, стандартын хүрээнд тодорхойлж, дүгнэлт гарган, цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний талаар санал зөвлөмжийг тусгасан болно.

Abstract

In this paper, we determine to make conclusion about the situation of occupational safety and health in Mongolian mining sector in accordance with legal regulations and standards, and to reflect on the proposal to implement the necessary measures.

Оршил

Хөдөлмөр эрхлэх явдал бол хүний амьдрах эрхийн үндсэн эх сурвалж бөгөөд ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхийн хэрэгжилт нь хүний хөдөлмөрөөр баталгааждаг учраас ардчилсан нийгэмд хүн хөдөлмөрийн шударга, аятай нөхцөлөөр хангуулах, хөдөлмөр эрхлэлтийн хүрээнд хүн бүр ямар нэг ялгаваргүй

адил тэгш эрх эдлэх асуудлыг хуульчлан баталгаажуулдаг. Хөдөлмөрийн шударга аятай нөхцөлөөр хангуулах эрх нь гүйцэтгэж буй ажил мэргэжлийн онцлогт тохирсон адил цалин хөлс авах, ижил хэмжээний амралт эдлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн адил нөхцөлөөр хангагдах зэргээр хэрэгжих учиртай. Өөрөөр хэлбэл, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй бол хөдөлмөрийн харилцааны чухал асуудлын нэг юм.

Сүүлийн жилүүдийн төлөв байдлаас харахад, эрсдэл ихтэй ажлын байрыг олноор агуулдаг уул уурхайн салбарт үйлдвэрлэлийн осол хамгийн их буюу улсын хэмжээнд гарсан нийт ослын 1/4 нь ногдож байна.

Түүнчлэн уул уурхайн зарим ажлыг тухайлбал, нүүрс олборлох, тээвэрлэх, худалдаалахыг манай иргэд хувиараа гар аргаар болон хууль бус байдлаар эрхэлж байна. Тэдний ихэнх нь аюултай, хүнд хүчир, бохир ажлыг эрүүл ахуйн ямар ч баталгаагүй нөхцөлд өндөр аюул, эрсдэлийн дор гүйцэтгэж багахан хэмжээний орлого олж өрхийн амьжиргаандаа нэмэр болдог талаар иргэдийн дунд ихээхэн яригддаг ч энэ нь нэгэнт хууль бус эсхүл албан бус үйл ажиллагаа учраас осол эндэгдлийн мэдээлэлд нэгтгэгдэх, даатгалаас нөхөн олговор олгогдох зэрэг ажиллагаанаас ангид байж, үүний дүнд иргэд, тэдний ар гэрийнхэн, хүүхэд, эмэгтэйчүүд, хөгшчүүл хохирох өндөр эрсдэл хүлээж байгааг гүнзгийрүүлэн судалж бодлого, хууль тогтоомжид тусгах, засч сайжруулах хэрэгцээ байгаа болно.

Иймээс бид Монгол Улсын уул уурхайн

салбарт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэгжүүлэх ямар хэрэгцээ шаардлага эрхзүйн орчинд байгааг судлах зорилгоор энэ салбарын эрхзүйн бичиг баримтад дүн шинжилгээ хийж, үндэсний болон олон улсын холбогдох хууль тогтоомж, стандартын практик хэрэгжилтэд тохиолдож байгаа доголдол дутагдлыг илрүүлж цаашид засч залруулах талаар дүгнэлт, санал гаргахыг зорьлоо.

Нэг. Уул уурхайн салбарын ХАБЭА-н эрх зүйн зохицуулалт

Хөдөлмөр хамгааллын хүрээн дэх эрхийг хангах нь төрийн үүрэг юм. Монголын төр энэхүү үүргийнхээ хүрээнд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар баримтлах үндэсний бодлогыг 1992 онд батлагдсан шинэ Үндсэн хуулиас эхлээд дараах хууль тогтоомж, эрх зүйн актуудыг баталж мөрдүүлж байна. Үүнд:

Монгол Улсын Үндсэн хуулиар иргэд "...ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах... эрхтэй" болохыг хуульчлан тогтоосон бөгөөд Монгол Улсын Засгийн газар нь Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактаар¹ "аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад тохирсон ажлын нөхцлийг бүрдүүлэх"², Нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактаар "гадаад орчны болон үйлдвэрлэлийн эрүүл ахуйг бүх талаар сайжруулах"³ үүргийг хүлээсэн.

Түүнчлэн Улсын Их Хурлын 2003 оны 41 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсад хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөр"-ийн 2.4.1.4-д "...ажилчдын эрүүл мэнд, ахуйн болон хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, үйлдвэрлэлийн аюул, осолгүй ажиллагааг хангах, ажилчны эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалах механизмыг төгөлдөржүүлэхэд нийцүүлэн хөдөлмөрийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох арга хэмжээг авна", 2.4.1.7-д "хөдөлмөр хамгаалал, үйлдвэрлэлийн ариун цэвэр, эрүүл ахуйн улсын хяналтыг урьдчилан сэргийлэх, зөрчлийг таслан зогсооход голлон чиглүүлж, үр нөлөөг дээшлүүлнэ" гэж тус тус тодорхойлсон байна. Төр дээр дурьдагдсан иргэний Үндсэн хуулиар тодорхойлсон эрхийг хангаж, хамгаалахын тулд Хөдөлмөрийн тухай хуулийг 1999 онд баталж

мөрдүүлсэн ба энэ хуулийн 6-р бүлгийн 81-99-р зүйлүүдэд ХАБЭА-н талаарх зохицуулалт тусгасан. Үүний дараа Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай бие даасан хуулийг 2008 онд баталж мөрдүүлж байна. Ийнхүү хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлтэй холбогдсон харилцааг хуулиар зохицуулах болсон нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн харилцааг шинэ шатанд гаргахад нөлөөлсөн чухал эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

Энэхүү хуулийн зорилт нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи төрийн бодлого, үндсэн зарчмыг тодорхойлж, төрийн байгууллагын удирдлага, хяналтын тогтолцоо, ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангах, ажилтан, хөдөлмөр эрхлэгч иргэнийг эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад чиглэгдэж байгаа болно.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг дээрх хуулиар зохицуулахаас гадна "Хөдөлмөрийн тухай хууль", "Нийгмийн даатгалын тухай хууль", "Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль", "Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль" "Төрийн хяналт шалгалтын тухай хууль", Захиргааны хариуцлагын тухай, "Эрүүгийн хууль", "Ашигт малтмалын тухай хууль", "Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль", Тэсэрч дэлбэрэх бодис тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай, Галын аюулгүй байдлын тухай зэрэг хуулиудаар зохицуулж байна.

Түүнчлэн Монгол Улсад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн 120 гаруй стандарт болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн нийтлэг болон салбарын, салбар дундын дүрэм журам үйлчилж байгаагийн зэрэгцээ Засгийн газрын тогтоолоор батлагдсан "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах үндэсний 4 дэх хөтөлбөр, Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм, Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг 3,0 хувиар төлөх ажил олгогчийн жагсаалтыг хэрэгжүүлж байна.

Ийнхүү уул уурхайн салбарт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль эрх зүйн

1 Монгол Улс тус пактад 1974 онд нэгдэн орсон.

2 Тус пактын 7 дугаар зүйлийн 7.(b)-дэх заалт.

3 Тус пактын 12-ын b-дэх заалт.

орчин зохих хэмжээнд бүрдэж, ажилтны ая тухай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэхийг эрмэлздэг аж ахуйн нэгж, байгууллагын тоо сүүлийн жилүүдэд нэмэгдэж байна.

Гэвч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин төдийлөн буурахгүй ялангуяа уул уурхайн салбарт гарч байгаа осол, ослын улмаас амь насаа алдах явдал гарсаар байна. Үүний гол шалтгаан нь ажил олгогч, ажилтны аль альных нь сахилга, хариуцлага сул, аливаа асуудалд хайхрамжгүй, хэнэггүй, дураараа ханддаг байдал нөлөөлж байгаагийн зэрэгцээ үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх ойлголт олон нийтийн дунд хангалтгүй, энэ талын зан үйл хэвшил болоогүйтэй холбоотой.

Энэ байдлыг таслан зогсооход хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудалд тэргүүлэх ач холбогдол өгч, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэлбэрийг тодорхойлж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрх зүйн орчины шинэчлэлтэй уялдуулан одоогийн мөрдөж байгаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нийтлэг болон салбарын эрх зүйн актыг шинээр болон шинэчлэн боловсруулахад салбарын яамд, орон нутгийн төрийн захиргааны болон аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах шаардлагатай байна.

Дээр дурьдагдсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, эрх зүйн зохицуулалт нь нийтлэг, ерөнхий байдлаар тогтоогдсоноос уул уурхайн болон нүүрсний салбарт тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг тэр бүр хангаж чадахгүй байгаагаас хувь хүнээс эхлээд байгууллага, улс орон, нийт иргэдийг хамарсан олон давхар хохирлыг үүсгэхэд хүргэх явдал байна.

Иймд уул уурхайд зориулсан аюулгүй ажиллагааны арга зүйн удирдамжийг эрх бүхий байгууллага нь боловсруулан мөрдүүлэх, бичил уурхай эрхлэгчдийн аюулгүй байдлын асуудлаар төрийн хүлээх үүргийг нэмэгдүүлсэн зохицуулалтыг бий болгож, уул уурхайн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бүх асуудлыг нэгдсэн бодлогын хүрээнд цогц хэлбэрээр, үр дүнтэй, харилцан уялдаатай байдлаар зохицуулахын тулд “Уул уурхай дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” 176 дугаар конвенцид нэгдэн орох нь шаардлагатай байна.

Энэхүү конвенцийн хэм хэмжээ нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөл, аюултай тохиолдолд үүсэхээс **урьдчилан сэргийлэх, хамгаалах**, аюул, эрсдэл нэгэнт бий болсон тохиолдолд **таслан зогсоох**, хор аюулыг багасгах оновчтой **арга хэмжээг** яаралтай **зохион байгуулах**, өртөгсдийг **нөхөн сэргээх**, буруутай этгээдэд **хариуцлага тооцох** цогц зохицуулалтыг уул уурхайн салбарын онцлогт нийцүүлэн томъёолсон бөгөөд эдгээр цогц асуудалтай холбоотой харилцан хамаарал, өөр өөрийн онцлог бүхий эрх, үүргийг **ажилтан, ажил олгогч** болон **төрд** хүлээлгэсэн байдаг.


Хоёр. Монгол Улсын уул уурхайн салбарын ХАБЭА-н төлөв байдал

а) Үйлдвэрлэлийн осол

Үйлдвэрлэлийн ослын судалгаанаас⁴ харахад 2005-2012 онуудад нийт 3085 осол гарснаас хамгийн олон тохиолдсон нь 2008 онд 491, 2012 онд 400 осол, хамгийн бага тохиолдсон нь 2005 онд 320, 2007 онд 343 осол гарч байжээ. Ослын гаралтыг зургаас үзэхэд өссөн дүнтэй, цаашид нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.

2005-2012 онуудад ҮО-н улмаас нас барсан хүний тоо 748 байгаагийн 28,3 хувь буюу 212 тохиолдол нь уул уурхайн салбарт гарч, ослын улмаас нас барагсдын тоо буурахгүй, дахин сэргэх хандлагатай байна. Тухайлбал 2011 онд нас барсан тохиолдлын тоо 75 болж буурсан ч нийт ослын тоо өссөн дүнтэй, 2012 онд ослын тоо 400, нас барагсдын 87 болж нэмэгдсэн байна(Зураг 1).

Зураг 1. ҮО-н тохиолдол ба ослоор нас барагсдын тоо, 2005-2012 он




Уул уурхайн салбарт гарсан ослыг авч үзэхэд жил бүр дунджаар 71,1 осол тохиолдож байгаа нь нийт ослын 25 гаруй хувийг эзэлж байна(Зураг 2).

Зураг 2. Уул уурхайн салбар дахь ҮО-н

4 МХЕГ-ийн Санхүү, хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтын улсын алба

тохиолдол, нас баралтын эзлэх хувь




Уул уурхайн салбар дахь ослын байдалд дүн шинжилгээ хийж үзэхэд:

- Хүндийн зэргээр тодруулахад 36,9 хувьд хүнд хэлбэрийн осол, 40,2 хувьд хөнгөн хэлбэрийн осол эзэлж байна.
- Осолд өртөгсдийн хөдөлмөр зохицуулалтыг үзэхэд хөдөлмөрийн чадвар түр алдсан 57,2 хувь, тахир дутуу болсон 10,6 хувь,

хөдөлмөрийн нөхцөл сольсон 0,1 хувьтай байна.

- Осол өртөгсдийн 64,4 хувь нь 18-35 насны, 34,8 хувь нь 35-аас дээш насны ажиллагсад өртсөн байна.
- Ажилласан жилээр үзэхэд 5 хүртэл жил ажилласан ажиллагсад 47,6 хувь, 5-15 жил ажилласанд 33,3 хувь, 15-аас дээш жил ажилласанд 19,0 хувьтай тохиолдсон байна.
- Ослын шалтгааныг тодруулахад 27,6 хувь нь аюулгүй ажиллагаанд хангалтгүй суралцсанаас, 22,3 хувь нь уналт, нуралтаас, 13,1 хувь нь технологийн процесс зөрчсөнөөс, 9,4 хувь нь тээврийн хэрэгслийн эвдрэл гэмтлээс, 7,7 хувь нь тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал алдагдсан зэрэг шалтгааны улмаас гарсан байна(Зураг 3).

Зураг 3. Уул уурхайн салбарт гарч буй ослын шалтгаан



б) Мэргэжлээс шалтгаалах өвчлөл

Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төвийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс(ЭХМК)-т МШӨ-ий ХЧА, тэдгээрийн хувь хэмжээ, хугацааг тогтоодог бөгөөд 1975 оноос эхлэн тус төвд МШӨ-өөр хөдөлмөр зохицуулалт хийсэн байна.

1974-2009 оны хооронд тус төвийн хяналтанд байж, МШӨ-ий хувь тогтоолгосон архивын баримтаас үзэхэд нийт 8883 тохиолдол бүртгэгдсэний 46% нь уушигны гадны шалтгаант өвчин, 41% нь тулах, хөдлөх эрхтний өвчин, 9% нь химийн бодисын архаг хордлогоос үүдэх эмгэг, 3% нь шуугианы үүдэлтэй сонсгол бууралт, 0,4% нь ионжуулах цацрагийн нөлөөгөөр үүссэн өвчин эзэлж байна¹

МШӨ үүсч буй хугацаагаар авч үзвэл 1-5 жил ажилласан 50(1%), 6-10 жил ажилласан 446(8%), 11-15 жил ажилласан 1563(28%), 16-20 жил ажилласан 2238(40%), 21-ээс дээш жил ажилласан 1287(23%) өвчлөл бүртгэгдсэн байна.


2000-2008 онуудад шинээр оношлогдсон МШӨ-ийг судалж үзэхэд Шинээр **45** хүнд мэргэжлийн өвчин тогтоож, хяналтанд авсан нь урьд оны мөн үеийнхтэй харьцуулахад мэргэжлийн өвчний гаралт **2.2%-аар** ихэссэн байна(Хүснэгт 1).

Монгол улсын уул уурхайн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий төлөв байдал

Хүснэгт 1: 2000-2008 онуудад тогтоогдсон мэргэжлээс шалтгаалсан өвчлөл

Д/д	Өвчний нэршил	ӨОУА-10	Хүний тоо	Хувь	Оношийн тохиолдол
1	Багтраа	J45	1	2.2%	1
2	Цахиурын давхар ислийн шалтгаант уушиг тоосжих өвчин	J62	2	4.4%	1
3	Сүрьеэтэй хавсарсан уушиг тоосжих өвчин	J65	1	2.2%	1
4	Химийн бодисын шалтгаант амьсгалын замын өвчин	J68	18	40%	19
5	Үе мөч, мэдрэлийн ёзоорын өвчлөл	G54	12	22.2%	13
6	Шамбарам	I84	2	4.4%	1
7	Хавьтал, харшлын дерматит	L23	1	2.2%	1
8	Органик уусгагчийн хордлого	T52	1	2.2%	1
9	Хамар, залгиурын архаг үрэвсэл	J31	2	4.4%	1
10	Дууны хөвч болон төвөнхийн өвчин	J38	2	4.4%	1
11	Шуугианы нөлөөт сонсголын өвчин	H83	2	4.4%	1
12	Үе мөчний олдмол деформаци	M21	1	2.2%	1
13	Тавхайнаас бусад доод мөчний өвчин (энтезопати)	M76	1	2.2%	1
		Бүгд	45	100%	43

Зураг 4. 2010-2012 онд шинээр тогтоогдсон МШӨ-ий тохиолдлууд, салбараар⁵



с) ҮОМШӨ-д зарцуулсан даатгалын сангийн үзүүлэлт

2012 оны байдлаар нийгмийн даатгалын шимтгэлийн нийт орлогын 8,5 хувийг ҮОМШӨ-ий даатгалын сангийн орлого бүрдүүлж байна. ҮОМШӨ-нөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 2011 онд шимтгэлийн орлогын 0.24 хувийг, нийт зардлын 0,54 хувийг, 2012 онд шимтгэлийн орлогын 0.19 хувийг, нийт зардлын 0,45 хувь болж уг зардалд зарцуулж буй хөрөнгийн хэмжээ өссөн ч нийт дүнд эзлэх хувь буурсан дүн гарсан байна. ⁶

2009-2012 онуудад даатгалын сангийн

⁵ Эх сурвалж: Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төвийн 2012 оны үйл ажиллагааны тайлангаас

⁶ МХЕГ-ын "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн 2011, 2012 оны бүрдүүлэлт, зарцуулалтыг шалгасан дүнгийн тухай" мэдээ

Монгол улсын уул уурхайн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий төлөв байдал

орлогыг өмнөх онуудтай харьцуулахад 27.8-70.2 хувь хүртэл өссөн эерэг дүн гарсан хэдий ч ҮОМШӨ-өөс урьдчилан сэргийлэх зардал нийт орлогын 0.18-0.31 хувь(60.0-124.0 мянган төгрөг)-ийг эзэлж байгаа нь хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааг сайжруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хангалтгүй үзүүлэлттэй байгаа юм.

Даатгалын сангийн зарлагын зарцуулалтыг задлахад тахир дутуу, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт дунджаар 92.1 хувь, тэтгэмж төлбөрт 1.7 хувь, тэтгэврийн даатгалын шимтгэлд 2.8 хувь, рашаан сувиллын зардалд 2.4 хувь, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 0.5 хувь тус тус зарцуулагддаг байна(Хүснэгт 2).

Хүснэгт 2. ҮОМШӨ-ний даатгалын сангийн үзүүлэлтүүд

Д/д	Үзүүлэлтүүд	2008	2009	2010	2011	2012
1	ҮОМШӨ-ний даатгалын сангийн орлого, мян.төг	26808.0	23874.0	31327.0	49097.8	67942.9
2	ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага, мян.төг	14553.7	14962.2	15928.0	19190.9	26737.4
Үүнээс	Тахир дутуу, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт	13674.6	13776.2	14558.7	17409.4	24747.7
	Тэтгэмж, төлбөрт	468.7	237.4	250.8	319.3	352.8
	Тэтгэврийн даатгалын шимтгэлд		503.4	592.7	738.8	712.8
	Рашаан сувиллын зардалд		375.2	425.7	611.8	800.1
	Урьдчилан сэргийлэх арга хэмжээнд	60.0	70.0	100.1	111.6	124.0

Дүгнэлт

- Монгол улс ХАБЭА-н бие даасан нэг хууль, мөн хуультай холбогдох хөдөлмөрийн, ашигт малтмалын, галын гэх зэрэг 8 хууль, мөн ХАБЭА-н хуулийн хэрэгжилтийг хангах 10 гаруй төрлийн дүрэм, журмууд, цаашлаад 130 орчим төрлийн стандарттай байгаагаас үзэхэд ХАБЭА-н эрх зүйн орчны суурь тавигджээ.
- Хэдийгээр Монгол улсад ХАБЭА-н эрх зүйн орчны суурь тавигдсан боловч эрх зүйн баримт бичиг болон түүнийг хэрэгжүүлэх үндэсний тогтолцооны хүрээнд дараах нийтлэг дутагдалтай талууд байгаа нь уул уурхайн салбарын өнөөгийн ХАБЭА-н төлөв байдалд сөргөөр нөлөөлж байна.
 - ХАБЭА-н 130 гаруй төрлийн нийтлэг стандарт байгаа боловч 3 хувийг нь л цаашид мөрдөж ажиллахад шаардлага хангаж байгаа ба 97 хувьд нь ямар нэг сайжруулалтын өөрчлөлт хийх шаардлагатай болсон.
 - ХАБЭА-н тухай хуулийн хэрэгжилтийг үндэсний хэмжээнд зохион байгуулж, хангаж ажиллах үүрэгтэй төрийн шат шатны байгууллагуудын бодлогын залгамж чанар, ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагаа сул.
- Уул уурхайн салбар дахь үйлдвэрлэлийн ослын тоо сүүлийн 3 жилийн байдлаар буурсан үзүүлэлттэй байгаа ч ослын улмаас амь үрэгдэгсдийн тоо өссөн байна.
- Ослын шалтгаануудад аюулгүй ажиллагаанд хангалтгүй суралцсан, уналт ба нуралт, технологийн процесс зөрчсөн, тээврийн хэрэгслийн эвдрэл гэмтэл, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал алдагдсан зэрэг багтаж байна. Эдгээр нь гол төлөв хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, стандарт, дүрэм, журмын талаарх ойлголт, мэдлэг, мэдээлэл хөдөлмөр эрхлэгч иргэн, ажилтан, ажил олгогчдын аль алинд нь хангалтгүй байгаатай холбоотой.
- ҮОМШӨ-ийн даатгалын сангийн орлого сүүлийн жилүүдэд өссөн дүнтэй байгаа ч ХАБЭА-н урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 0.2 хувийг зарцуулж байгаа нь ҮО-ыг бууруулах, МШӨ-өөс сэргийлэх арга хэмжээнд хангалтгүй байгааг харуулж байна.

Санал, зөвлөмж:

- Олон Улсын “Уул уурхай дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” 176 дугаар

конвенцид нэгдэн орох.

2. Монгол улсын уул уурхайн салбарт дэлхийн дэвшилтэт техник, технологи нэвтрэхийн хэрээр ХАБЭБ-н салбарын хууль эрх зүйн орчинг улам боловсронгуй болгох, урьд өмнө батлагдан хэрэглэж байсан журам, стандартуудыг орчин үеийн шаардлагад нийцүүлэх.
3. Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг судалж, бүртгэх асуудлыг Хөдөлмөрийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 7-д үйлдвэрлэлийн осолтой адилтган үзэж, судалж бүртгэнэ гэж заасан байдаг боловч бүртгэл судалгаа хийх анхан шатны болон тайлангийн маягт, бүртгэх тогтолцоо байдаггүй зэрэг шалтгаануудын улмаас өвчний тайлан мэдээ улсын хэмжээнд нэгтгэгдэж гарахгүй, тодорхой бус, хаалттай байгааг анхаарч, эрх зүйн зохицуулалт хийх.

ХАВСРАЛТ

2005-2012 онд нийт гарсан болон уул уурхайд салбарт тохиолдсон үйлдвэрлэлийн ослын мэдээ 7

Ослын мэдээ	Нийт															
	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012
Ослын тоо	320	396	343	491	366	366	403	400	55	70	36	95	77	85	76	75
Бүлэг ослын тоо	16	31	13	27	16	15	15	14	7	9	1	8	4	4	3	8
Осолд орсон хүний тоо	366	460	379	671	410	398	403	424	65	89	37	123	81	98	80	91
Эмэгтэй	111	167	85	151	104	92	112	111	14	2	4	7	4	9	5	2
Тахир дутуу болсон	58	58	65	135	37	44	40	35	10	12	6	18	3	10	4	8
ХЧТАлдсан	239	268	217	357	313	273	310	301	41	33	23	63	55	70	45	50
Өөр ажилд шилжсэн	1	0	9	17	2	1	6	1	1	0	0	0	0	0	0	0
Хүний амь үрэгдсэн	68	134	88	162	54	80	75	87	13	44	8	42	23	18	31	33
Хэлбэр	139	168	153	268	181	141	142	165	37	14	17	37	26	34	11	34
Хүнд	159	158	138	241	175	177	214	172	15	19	12	44	32	45	38	24
Хөнгөн	1	14	21	7	0	0	2	3	0	4	1	0	0	0	0	0
18 нас хүртэл	187	254	202	363	220	206	224	235	44	53	24	84	52	53	50	67
18-35 нас	182	192	156	301	190	192	205	186	21	32	12	39	29	44	30	24
35-аас дээш нас	117	171	129	260	167	155	183	187	32	50	19	41	45	35	38	56
5 хүртэл жил	107	161	141	240	138	127	107	126	16	28	9	60	26	33	25	24
5-15 жил	143	128	109	171	105	116	141	111	17	11	9	22	10	29	17	11
15-аас дээш жил	64	116	68	192	113	112	101	102	7	21	9	32	24	20	20	14
Уналт, нуралт	24	38	28	79	84	36	56	30	4	4	3	12	6	11	9	13
Тээврийн хэрэгслээс	16	26	15	35	13	5	4	15	2	6	2	10	4	1	3	4
Өргөх механизмгаас	29	33	22	45	22	32	15	14	5	8	3	12	5	10	4	4
Тоног төхөөрөмжөөс	35	52	29	62	29	34	24	28	10	12	7	13	14	17	5	8
Технологийн зөрчлөөс	82	85	70	124	48	75	64	70	23	27	7	33	17	23	21	31
Аюулгүй ажиллагаанд суралцаагүйгээс	7	20	26	16	8	8	20	4	0	0	6	2	2	0	2	0
Ажлын хувцас	109	90	121	118	93	96	147	161	14	11	0	9	9	12	16	17
Бусад																

7 МХЕГ-ийн Санхүү, хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтын улсын алба

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ:

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992
2. Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, 1999
3. Монгол Улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008
4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах үндэсний хөтөлбөрүүд, 1997-2010

ДҮРЭМ ЖУРМУУД

1. Үйлдвэрлэлийн осол судлан бүртгэх дүрэм, 2009
2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм, 2008
3. Монгол Улсын Хөдөлмөрийн сайдын А/53 тоот тушаалаар батлагдсан “ХАБЭА-н сургалт зохион байгуулах, шалгалт авах журам”, 2013

СТАНДАРТУУД:

1. MNS4969:2000 ХААЭА-н сургалтын зохион байгуулалт үндсэн дүрэм, 2000
2. MNSOHSAS18001:2012 болон олон улсын OHSAS18001:2007-ХАБЭА-н удирдлагын тогтолцооны стандарт
3. ХАБЭА-н стандартын эмхэтгэл, 2008

НОМ, СУДАЛГААНЫ ТАЙЛАН БОЛОН БУСАД МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖУУД

1. ХАБЭА-н хууль, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон тушаал, шийдвэрүүд, 2013
2. Монгол Улсын ҮСХ, Статистикийн эмхэтгэл, 2012
3. Уул уурхайн яам. Монголын уул уурхайн салбарын хүний нөөцийн өнөөгийн төлөв байдал судалгаа, 2013
4. Геологи, уул уурхайн салбарын 2013-2014 оны хамт(тариф)-ын хэлэлцээр, 2013
5. МХЕГ-ын Санхүү, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын хяналтын улсын албаны сүүлийн 8 жилээр гаргасан үйлдвэрлэлийн ослын судалгаа
6. МХЕГ-ын Санхүү, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын хяналтын улсын албаны 2012 онд “Өмнийн говь-2012” нэгдсэн шалгалтын тайлан
7. НДЕГ-ийн ҮОМШӨ-ний даатгалын сангийн сүүлийн таван жилийн үзүүлэлтүүд
8. Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төвийн Хөдөлмөрийн нөхцөл судлалын хэлтсийн тайлангаас
9. МШӨ, ХЭМСТ-ийн 1975-2009 оны архивын судалгаа /www.hemst.mn/
10. Нэн түрүүнд Хөдөлмөрийн аюулгүй байдал -2013 бага хурлын илтгэлүүдийн эмхэтгэл 2013